БАТЛАВ
ХӨДӨЛМӨР ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ө.БАТ-АМГАЛАН
2025 оны 04 дүгээр сарын ....-ны өдөр

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНД БОЛОН БАЙНГЫН АСАРГАА ШААРДЛАГАТАЙ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНД ҮЗҮҮЛЭХ ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООНД ТҮШИГЛЭСЭН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ҮЗҮҮЛЭХ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ /БАГЦ-1/

Сүхбаатар аймаг

Ерөнхий сүйл.

Энэ техникийн тодорхойлолт нь Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1, 18.1.2, 18.1.3, 18.1.5, 18.1.6, 18.1.7-д заасан үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай техникийн үзүүлэлтийг тусгасан болно.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ нь дараах төлөвтэй төрөлтэй байна.

- 18.1.1. Амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авъяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах сургалт зохион байгуулах
- 18.1.2. Зөвөлгөө өгөх үйлчилгээ
- 18.1.3. Сэргээн засах үйлчилгээнд хамруулах
- 18.1.5. Өдрийн үйлчилгээнд хамруулах
- 18.1.6. Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах
- 18.1.7. Иргэн, түүний гэр бүлийн хэрэгцээнд тулгуурласан нийгмийн халамжийн бусад үйлчилгээ үзүүлэх

Ажлын цар хүрээ.

Уг нь үйлчилгээ нь Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 02 дугаар сарын 11-ны өдрийн А/35 дугаар тушаал, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 02 дугаар сарын 11-ны өдрийн А/53 дугаар тушаалаар үйлчилгээний чанарт тавигдах шалгуур, журам, аргачилалын дагуу Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д заасны дагуу зорилтот бүлгийн иргэдэд үйлчилгээг үзүүлнэ.

Тавигдах шаардлага:

№	Нэр, төрөл	Тавигдах шаардлага
1	Хүний нөөц	-Мэргэжлийн нийгмийн ажилтан /гэрээт-1/ -Сувилагч /гэрээт-1/ -Асаргааны ажилтан /орон тооны эсхүл гэрээт/-1 -Сайн дурын ажилтан /орон тооны эсхүл

		гэрээт/-1
2	Ерөнхий шаардлага	-Аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага бол хуулийн этгээдийн гэрчилгээтэй байх /Сүхбаатар аймгийн нутаг байршилтай, харьяалалтай байх/ -Үйчилгээ үзүүлж буй байр тогтмол байршилтай байх -Үйлчилгээ үзүүлэх эсвэл мэргэшсэн боловсон хүчинтэй байх -Боловсон хүчний мэргэжлийн дипломтой байх -Ажлын байрны тодорхойлолттой байх -Чиглэл, зорилго, хүрэх үр дүнгийн талаарх мэдээллийг агуулсан сургалтын хөтөлбөртэй байх -Ажил үүргийн хуваарьтай байх -Үйлчилгээг үзүүлэх заавар /дотоод журам/-тай байх -Шуурхай тусламж түргэн үзүүлэх зохицуулалттай байх -Архи,мансуурах донтой, сэтгэц, сүрьеэ зэрэг халдварт өвчтэй хүн ажилуулахгүй байх -7 хоног бүрийн үйлчилгээний хөтөлбөртэй байх -Сүүлийн 1 жилийн үйл ажиллагааны тайлантай байх
3	Техникийн чадавхи болон туршлагын шаардлага	-Өөрийн өмчийн болон түрээсийн байртай байх -Эрүүл ахуйн шаардлага хангасан тохилог орчин хүртээмжтэй дэд бүтэцтэй байх /гал тогоо, хоолны өрөө, бие засах газар/ -Байгууллагын нэр, холбоо барих утас, байршил, ажиллах цагийн хуваарийг ил тод байршуулсан байх -Ганцаарчилсан зөвөлгөө өгөх өрөөтэй байх

		-Эмнэлэгийн анхан шатны тусламж үзүүлэх хэрэгсэлтэй байх -Гэрээр үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатаы тээврийн хэрэгсэлтэй эсхүл гэрээт жолооч тээврийн хэрэгсэлтэй байх

Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй өрх, эдгэшгүй хүнд өвчтэй иргэнд үзүүлэх олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний үнэ тариф /Багц-1/

№	Ажилтан	Тоо	Үйлчлүүлэгчийн тоо /хамгийн багадаа/	Нийт ажиллах сар	Сарын цалин, урамшуулал /төгрөгөөр/	Жилийн нийт зардал /төгрөгөөр/
1	Мэргэжлийн нийгмийн ажилтан /гэрээгээр/	1	Өдөрт 5-аас доошгүй кейс	5	1,500,000	7,500,000
2	Сувилагч	1	Өдөрт 10-аас доошгүй үйлчлүүлэгч	5	1,500,000	7,500,000
3	Асаргааны ажилтан	1	Өдөрт 10-аас доошгүй үйлчлүүлэгч	5	1,500,000	7,500,000
4	Сайн дурын ажилтан	0,5	Өдөрт 5-аас доошгүй үйлчлүүлэгч	5	750,000	3,750,000
5	Үйл ажиллагааны зардал /нийт зардлын 20 хувиар тооцох/				1,050,000	5,250,000
Нийт						31,500,000

Тайлбар: Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй өрх, эдгэшгүй хүнд өвчтэй 1 иргэнд 7 хоногийн хугацаатай үйлчилгээ үзүүлэх ба нийт 150 иргэн хамрагдана.

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ БОЛОВСРУУЛСАН
ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ НАРИЙН БИЧИГ Б.ЭНХНАРАН